

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэнд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай

2025.12.01

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Засгийн газрын 2024 оны “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг танилцуулж байна.

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Засгийн газрын 2024 оны “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд төлөвлөгөөний зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, явцын үнэлгээ хийж, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Хяналт шинжилгээний ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг тооцох аргачлалыг ашиглан гүйцэтгэв.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2 зорилтын 7 арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 6 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 97,5%-тай байна. 1 арга хэмжээ чиг үүргийн дагуу өөр байгууллага хариуцан хийнэ.
2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1 бүлэг зорилтын 3 арга хэмжээнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд 92%-тай байна.
3. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 бүлэг, 1 зорилтын 2 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 95%-тай байна.
4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт 2 зорилтын 2 арга хэмжээ төлөвлөснөөс 1 арга хэмжээ санхүүжилт шийдвэрлэгдээгүй тул хэрэгжээгүй бөгөөд үлдсэн 1 арга хэмжээний биелэлт 95% байна.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Монгол Улсын Засгийн газар болон нийслэлийн урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд болон бусад нийслэлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зарим заалтуудыг хэрэгжүүлэх төсөв хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна.

Манай байгууллагатай холбоотой бодлогын баримт бичгүүдээс 2025 онд гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах болон ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган шинээр барилгажуулах төслийн хүрээнд хийгдэж байгаа ажлууд үр дүнтэй хэрэгжиж тодорхой үр дүн гарсан.

“Баянголын амын орлогод нийцсэн орон сууц төсөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гүйцэтгэлийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Цаашид эдгээр ажлыг эрчимжүүлэх талаар дээд шатны байгууллагууд хариуцсан хэлтэс, мэргэжилтнүүд тодорхой шийдэлд хүрч ажлаа зөв оновчтой төлөвлөх, уялдаа холбоотой ажиллах, зохион байгуулах, удирдлагуудад асуудлаа танилцуулж ажиллах хэрэгтэй.

Хяналт-шинжилгээний чиглэлээр үр дүнг үндэслэн, цаашид бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээний үр дүн, гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, үнэлгээнд хамрагдаж буй хэлтэс, хариуцсан албан хаагч нарт хандаж дараах зөвлөмжийг хүргэсэн.

Тав. Зөвлөмж

1. Бодлогын баримт бичгүүдийн зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх тал дээр анхаарч ажиллах.
2. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг тайлагнахдаа товч тодорхой, үр дүнг тооцсон, тоо баримтыг нэгдсэн байдлаар гаргаж, арга хэмжээг хэмжих, үнэлэх үндэслэл бүхий байх.
3. Хэрэгжилтийг хэт нуршихгүй, 2000 тэмдэгтэд багтааж тайлагнадаг байх.
4. Тухайн арга хэмжээг үнэлэх боломжгүй, зорилго нь тодорхойгүй, гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан ажлуудад дүгнэлт хийж, баримтаар нотолж, удирдлагууд болон холбогдох дээд шатны байгууллагад цаг алдалгүй мэдээлж байх.

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ:

Ж.БОЛОРТУЯА

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЧАНЦАЛДУЛАМ

Дэлгэрэнгүй мэдээлэл авах:

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Х. Чанцалдулам

Хаяг утасны дугаар:

Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг 23-р хороо Арцатын ам Наадамчдын зам 1201,
70110733